

КОНВЕРГЕНЦИЙН ҮЙЛ ЯВЦ ОНМХ-Д НӨЛӨӨЛӨХ НЬ

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: конвергенцийн онол, шинжлэх ухаан технологийн хувьсгал, мэдлэгийн технологи ба мэдээллийн үйлдвэрлэл, телехарилцааны зах зээл, медиа-систем.

Сүүлийн үед хамгийн эрчимтэй өөрчлөгдөж, цаг хугацаатай уралдан даяарчлагдаж буй нийгмийн институт бол сэтгүүл зүй буюу орчин үеийн медиа-систем, бүр тодруулж хэлбэл олон нийтийн мэдээллийн харилцаа юм. Үүнд хамгийн гол нөлөө үзүүлж буй хоёр гол хүчин зүйл бол орчин үеийн технологийн дэвшил ба нийгмийн бүх хүрээг хамран өрнөж буй улс төрийн өөрчлөлт гэж хэлж болно.

Орчин үед Интернет олон нийтийн мэдээллийн харилцааны түүхэнд урьд өмнө үзэгдэж байгаагүй хурдаар олон нийтийг байлдан дагуулж байна. 50 сая хүлээн авагчтай болоход Америкийн радиод 38 жил, телевизэд 14 жил шаардагдаж байсан бол Интернет ердөө дөрөвхөн жилийнх дотор тийм тооны хэрэглэгчтэй болсон¹ нь үүний тод жишээ юм. Энэхүү цоо шинэ үзэгдлийг сэтгүүл зүй болон олон нийтийн мэдээлэл харилцааны онолыг судлаачид конвергенцийн

буюу ОНМХ-үүдийн нэгдэн нийлэх, ойртон нягтрах онолтой холбон тайлбарлаж байна. Ялангуяа сэтгүүл зүйн ирээдүйн талаар, хөгжлийн өнөөгийн чиг хандлагын талаар ярихдаа конвергенци хэмээх нэр томъёог хэрэглэдэг болсон нь санамсаргүй хэрэг биш юм. Эхлээд энэ ойлголтын мөн чанар, утга учрын талаар товч тайлбарлахыг оролдъё. Конвергенция (латины "convergere" – *ойртох, нэгдэн нийлэх* гэсэн үгнээс гаралтай) хэмээх нэр томъёог биологи, угсаатны зүй, хэл шинжлэлийн салбарт нэлээд дээр үеэс хэрэглэж эхэлсэн бөгөөд хоорондоо төстэй үйл явцын нэгдэн нийлэх, ойртох үзэгдлийг илэрхийлж ирсэн онцлогтой. Харин энэ ойлголтыг Өрнөдийн философичид, нийгэм судлаачид 1950-иад оны үеэс нийгэм-улс төрийн шинжлэх ухаанд хэрэглэж эхэлсэн юм. Тэд шинжлэх ухаан-техникийн дэвшил, ололтод тулгуурлан капиталист болон социалист нийгмийн хоорондох ялгаа аажим аажмаар арилах тухай таамаглал дэвшүүлж байв. Америкийн судлаач У.Ростоу, Голландын эрдэмтэн Я.Тинберген нарын бодлоор конвергенцид онцгой ач холбогдол өгөх гол шалтгаан, нөлөөлөх хөдөлгөгч хүч нь эсрэг тэсрэг

үзэл суртал бүхий нийгмийн формацийн хувьд шинжлэх ухаан-техникийн хувьсгал байсан юм. Тухайн үед ийм байр суурь технологийн харилцан хамаарал, зүй тогтол дахь конвергенцийн онолыг дэмжигчийн зүгээс томоохон эсэргүүцэлтэй тулгарч байсан боловч нийгэм судлаачдын дунд конвергенцийн үйл явцын талаарх шинэ үзэл бодол богино хугацаанд өргөн дэлгэрсэн ажээ. Америкийн социологич Д.Беллын 1962 онд хэвлүүлсэн “Үзэл суртлын төгсгөл” ном нь нийгэм-улс төрийн конвергенцийн онолын хөгжлийн оргил цэг нь болсон түүхтэй. Тэрбээр өөрийнхөө өмнө нь дэвшүүлж байсан аж үйлдвэрлэлийн дараах нийгмийн тухай үзэл санааг нийгмийн шинэ хэв маяг үүссэн тухай дүгнэлтээр баяжуулж, улам гүнзгийрүүлж чадсанаараа онцлог юм.

Америкийн социологич шинэ нийгэм ирээдүйн эдийн засгийн хоёр чухал бүрэлдэхүүн хэсэг болох мэдлэгийн технологи ба мэдээллийн үйлдвэрлэлд тулгуурлан хөгжих болно гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Д.Белл мэдээллийн нийгмийн тухай төсөөллийн эхлэлийг тавьснаараа гавьяатай бөгөөд үүнийг олон эрдэмтэн судлаач хүлээн зөвшөөрч, шинэ утга санаа, агуулгаар баяжуулан хүлээн авсан юм. 1970-аад оны үеэс энэ ойлголтыг компьютер, утсан холбоо, зурагт зэрэг мэдээлэл харилцааны технологийн хэрэгслүүдийг нэгтгэх үйл явцыг илэрхийлэх утгаар өргөн хэрэглэж эхэлсэн. Цаашид энэ нэр томьёо Америкийн телехарилцааны зах зээл болон 1980-аад оны үеийн Баруун Европын нэвтрүүлгийн зах зээлийн зохицуулалтын талаарх маргаан, мэтгэлцээний үед олон нийтийн мэдээллийн

харилцааны салбарт улам хүчтэй нэвтэрсэн юм. Харин 1990-ээд оноос Интернет сая сая хүний өдөр тутмын амьдралд хүчтэй нэвтэрч эхэлснээр конвергенцийн тухай маргаан шинэ практик, агуулгаар баяжсан түүхтэй.

Орчин үед ОНМХ-ийн ирээдүйн тухай аливаа асуудлын тухай ярихдаа конвергенцийн тухай хөндөхгүй өнгөрөх боломжгүй болсон. Өнөөдөр энэ нэр томьёог олон нийтийн мэдээллийн хүрээн дэх эрс шинэчлэл, томоохон өөрчлөлт гэсэн ойлголттой бараг ижил утгаар хэрэглэх болсон нь ч үүнтэй холбоотой юм. Мэдээлэл харилцааны салбарт өрнөж буй өөрчлөлтийн талаарх маргаан, мэтгэлцээний явцад конвергенци хэмээх ойлголтыг судлаачид, ОНМХ-ийн мэргэжилтнүүд олон янзын утгаар тайлбарлаж, нэлээд өргөн хүрээнд авч үзэж байгаа нь ажиглагддаг. Тэдний ихэнх нь конвергенцийг ойрын арван жилд зөвхөн олон нийтийн мэдээллийн харилцааны системийг төдийгүй, түүнтэй холбоотой янз бүрийн үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчлөх үйл явц мөн гэж үздэг байна. ОНМХ-ийн конвергенцид хамгийн ойрхон ойлголт бол “нэгдэн нийлэх” гэсэн нэр томьёо юм. Янз бүрийн тохиолдолд өөр өөр үйл явцын тухай ярьдаг боловч дээрх нэр томьёо энэ ойлголтын гол санааг хамгийн зөв, оновчтой илэрхийлдэг гэж хэлж болно. Нэгдүгээрт, энэ бол технологийн нэгдэн нийлэх үйл явц бөгөөд кабель, утасны сүлжээ, сансрын холбоо зэрэг янз бүрийн техник хэрэгсэл болгонд хэрэглэгчдэд мэдээллийг дамжуулах боломж олгоно гэсэн үг. Ийм мэдээлэл харилцааны технологийн нэгдлийн үндсэн дээр дижитализаци буюу агуулгыг

тоон хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа явагддаг бөгөөд энэ нь сонин хэвлэлийн үг, хөдөлгөөнт дүрсийг “ижил төвшин”-д тавих боломж олгодог. Агуулгын тоон үйлдэл бол ОНМХ-ийн онцлог, үйлдвэрлэл, технологиос үл шалтгаалан олон нийтэд янз бүрийн хэлбэрээр түгээхэд нөлөөлдөг. Мөн технологийн конвергенци нь орчин үеийн мэдээлэл харилцааны нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь интер-актив буюу харилцан санал солилцох, яриа өрнүүлэх шинж болоход гол үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ техник, тоног төхөөрөмжийг хөнгөн, овор хэмжээ багатай, авсаархан, авч явахад амар хялбар болгох боломж олгодог.

Хоёрдугаарт, конвергенци гэдэг бол юуны өмнө янз бүрийн мэдээллийн хэрэгслүүдийн нэгдэн нийлэх, ойртон нягтрах үйл явц бөгөөд үүний үр дүнд чухам ямар мэдээллийн хэрэгслийн тухай ярьж байгаагаа тодорхойлоход ихээхэн хүндрэл учирч эхэлсэн. Интернет дэх Радио, компакт-дискэн дэх Британика нэвтэрхий толь, кабелийн телевиз дэх видеокино, эсвэл халаасны жижиг мэдээлэл хүлээн авагч, гар утсаар дамжуулсан зар сурталчилгааны мэдээлэл зэрэг орчин үеийн мэдээллийн техник хэрэгслийн боломжийг тоолж баршгүй болсон. Ингэж нэг мэдээллийн хэрэгсэл өөр мэдээллийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэж, янз бүрийн мэдээллийн сувгуудын “үүрэг, үйл ажиллагаа”

нь өөрчлөгдөж, янз бүрийн сувгуудаас ижил агуулгатай мэдээлэл авах боломж эрс нэмэгдсэн нь бидний өмнөх үеийн мэдээлэл харилцааны хэрэгслүүдийн тухай ойлголтыг үндсээр нь өөрчилсэн гэж хэлж болно. Ийм маягаар ОНМХ-үүд нэгдэж, янз бүрийн сувгуудын хувьд нийтлэг агуулга бүхий бүтээгдэхүүн бий болж байгаа нь шинэ холимог бичлэгийн

төрлүүд үүсэхэд нөлөөлж эхэлсэн. Инфотейнмент (information+entertainment) телевизийн эриний бүтээгдэхүүн байсан бол Интернетийн эрин эдотейнментийг (education+entertainment), орчин үеийн мэдээллийн хувийн сувгууд инфорториалыг (information+editorial) бий болгосон нь үүний тодорхой жишээ юм².

«

Технологийн конвергенци нь орчин үеийн мэдээлэл харилцааны нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь интерактив буюу харилцан санал солилцох, яриа өрнүүлэх шинж болоход гол үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ техник, тоног төхөөрөмжийг авч явахад амар хялбар болгох боломж олгодог.

»

Гуравдугаарт, конвергенци гэдэг бол зах зээлийн нэгдэл мөн. Өнгөрсөн зууны мэдээллийн бизнесийн томоохон төлөөлөгчдөөс эхлээд орчин үеийн ОНМХ-ийн үйлдвэрлэл хүртэл теле харилцааны салбар, ахуйн техник хэрэгслийн үйлдвэрлэл, мэдээллийн технологиудтай нэгдэн нийлэх үйл явц маш эрчимтэй явагдаж байна. Үүний үр дүнд цоо шинэ нэгдмэл зах зээл үүсч, энд мультимедиагийн, сүлжээний болон программ бүтээх, боловсруулах үйлчилгээ, үйл ажиллагаа нягт уялдаа холбоотой явагдах болсон. Өнөөдөр Барууны эрдэмтэд конвергенцийн үйл явцыг зуун хувь хүлээн зөвшөөрсөн мөртлөө конвергенцийн чухам ямар хэлбэр, хэв маяг

бусдыг байлдан дагуулсан бэ гэдэг асуудлын хүрээнд маргасаар л байна. Үнэн хэрэг дээрээ энэ бол тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэдгийн нэгэн адил мөнхийн асуудал гэдэг нь тодорхой юм. Харин конвергенци бол эрчимтэй хөгжиж буй үйл явц бөгөөд ОНМХ-ийн хөгжлийн чиг хандлагыг аль хэдийд тодорхойлж чадсан гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Ер нь ОНМХ-ийн хөгжлийг Маршалл Маклюэнээс эхлээд олон эрдэмтэн судлаач технологийн хөгжилтэй холбон тайлбарлаж ирсэн бол сүүлийн үед мэдээллийн технологи ОНМХ-ийн хөгжлийг бус, түүний эдийн засгийг, бас зах зээлийг үндсээр нь өөрчлөх болно гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Эдийн засагчид орчин үеийн ОНМХ-ийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүчнүүдийг судлах явцад түүний дараах дөрвөн макроэдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлсон байдаг. Энэ бол:

- Үндэсний эдийн засгийн бүс нутгийн хэмжээн дэх нэгдэл (тухайлбал, Европын холбоо);
- Төр засаг үзэл суртлаас хараат бус, прагматик байдлаар үйл ажиллагаа явуулах орчин үүсч эхэлсэн;
- Технологийн хөгжил дэвшил;
- Глобаль өрсөлдөөн нөлөөлөхүйц даяарчлагдсан эдийн засгийн хөгжил юм.

ОНМХ-ийн эдийн засагт үзүүлэх шинэ технологийн нөлөөллийн талаарх санал дүгнэлт нэгдмэл байна. Харин хэвлэл мэдээллийн чиглэлээр мэргэшсэн эдийн засагчид орчин үеийн ОНМХ-үүдийн хөгжил дэх технологийн конвергенцийн үр дагаварыг харгалзан олон

жилийн турш ноёрхож ирсэн онолын үндэслэлийг үгүйсгэж, ойрын хэдэн жилд олон нийтийн мэдээллийн харилцааны эдийн засгийн бүтэц үндсээр нь өөрчлөгдөх болно гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Зах зээлийн хөгжлийн нөлөөгөөр үүссэн ОНМХ-үүдийн концернийг олон жилийн туршид медиа-үйлдвэрлэлийн хөгжлийн гол чиглэл гэж үзэж байсан. Хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгслүүдийг нэг гарт төвлөрүүлсэн мэдээллийн магнатуудад улс төрчид төдийгүй хүлээн авагчид ихээхэн болгоомжтой хандаж, мэдээллийн зах зээлд аюул учруулах болно гэж үзэж байв. Гэхдээ ардчилал, олон ургальч үзэл, улс төр, соёл, хэл шинжлэлийн тодорхой төлөөллүүдийн ийм эргэлзсэн хоёрдмол үзэл бодолд учрах аюулыг шинэ медиа-магнатуудын эдийн засгийн чадавхи, тогтвортой байдлаар нөхөн зохицуулж ирсэн гэж хэлж болно.

ОНМХ-үүдийн ийм төвлөрөл нь мэдээллийн хэрэгслүүдийн бие дааж чөлөөтэй хөгжих боломжийг хязгаарлаж байсан боловч медиа-үйлдвэрлэл тогтвортой хөгжих, шинэ нөөц боломж олж авахад чухал нөлөө үзүүлсэн юм. Гэхдээ хэн ч хүлээж байгаагүй өвөрмөц үзэгдэл ажиглагдсаныг судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. 1980-аад оноос зах зээлийн дарангуйлал, нэгдэн нийлэх босоо тогтолцооны үр дүнд Америк, Баруун Европын томоохон хэвлэл мэдээллийн үйлдвэрүүдийн хувьцааны зах зээлийн ханш буурч, эдийн засгийн байдал нэлээд муудаж эхэлсэн. Тиймээс өнгөрсөн арван жилийн дотор нэгдэн нийлсэн Тайм Уорнер, Виакон, Дисней зэрэг томоохон мэдээллийн концернүү-

дийн удирдагчид өөрсдийн үйл ажиллагааны гол хэсгийг хэвлэл мэдээллийн уламжлалт төрлүүдэд чиглэлүүлэхээр ярьж эхэлсэн юм.

Орчин үеийн медиа-концернүүд хоёр төвшинт бүтэцтэй бөгөөд бүх нөөц хөрөнгийн 20 хүртэлх хувийг туслах үйлдвэрлэлд зориулж, үлдсэн 80 хувийг мэдээллийн үйл ажиллагаанд зарцуулж байна. Үүний тод жишээ бол мэдээлэл, цэнгээнт нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг Дисней компани юм. Энэ компани цаашид шинэ радио, телестанци худалдан авахаа зогсоож, Интернет болон цахим мэдээллийн үйл ажиллагаа болон бэлтгэн гаргаж буй бүтээгдэхүүний агуулгад илүү их анхаарал хандуулах ажээ. Үүнийг конвергенцийн үйл явцын үр дүнд хоорондоо нэгдсэн ХМХ-үүдийн эдийн засгийн үр ашиг буурч эхэлсэнтэй холбон тайлбарласан байдаг. Орчин үеийн хэвлэл мэдээллийн зах зээлийн загварыг хуучин нийтлэг шинжтэй байсан үйл явцын эсрэг чиглэгдсэн буюу нийтлэл, нэвтрүүлгийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх замаар төлөвшиж байгаа гэж хэлж болно. Энэ нь конвергенцийн явцад тухайн компаниудын нөөц боломж, техник хэрэгслүүдийн хүчийг тарамдуулж, өрсөлдөх чадварыг сулруулахад нөлөөлдөг байна. Конвергенци орчин үеийн олон нийтийн мэдээллийн үйлдвэрлэлээс нэгэн зэрэг стратегийн уян хатан бодлого, зах зээлд туйлын тогтвортой байхыг шаардаж байна. Барууны судлаачид конвергенци бол одоогийн мэдээллийн зах зээлийг дахин хуваарилахад хүргэх болно гэсэн дүгнэлт хийснийг анхаарч үзүүштэй юм. ОНМХ-үүдийн сонины, нэвтрүүлгийн, кабелийн зэрэг өмнөх үеийн хуваари-

лалтыг хадгалсан уламжлалт үйлдвэрлэлийн оронд ахуйн, техник, технологийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, түгээлтийн сувгуудыг олшруулах, агуулгын хувьд шинэ бүтээгдэхүүнийг бий болгох зэрэг үйлдвэрлэлийн шинэ төрөл, чиглэлүүд үүсч байна. Хэдийгээр байнгын өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагатай тулгарч байгаа ч мэдээлэл-харилцааны энэхүү шинэ салбарт манлайлагчид төрөн гарч төлөвших шатандаа орж эхэлсэн. Тухайлбал, теленэвтрүүлгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх салбарт Дисней/Эй-Би-Си, Тайм Уорнер, Эн-Би-Си, Фокс зэрэг нөлөө бүхий томоохон компаниуд манлайлж, киноны хувьд ч Дисней, Виакон, Тайм Уорнер гол байр эзэлдэг бол радиогийн хувьд Вестингауз компани тэргүүлдэг байна. Энэ бүхнээс зах зээлийн шинэ сектор дэх нөхцөл байдал өнгөрсөн арван жилийн түүхтэй нэлээд ойролцоо байгааг төвөггүй ажиглаж болно. Эдийн засгийн хувьд тэргүүлэгч компаниудын үйл ажиллагаа нь уламжлалт зах зээлийн бүтэц буюу олигополи шинжийг хадгалсан хэвээр байна. Үүнээс үзэхэд нэгдэн нийлж буй зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг цөөн тооны оролцон тоглогчид тодорхойлж, хүч чадавхи, нөөц боломжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгааг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Одоо конвергенцийн улс төрийн асуудал, түүний утга учрын талаар товч өгүүлье. Конвергенци бол зөвхөн мэдээллийн технологи, мэдээллийн агуулга, мэдээллийн зах зээлд томоохон өөрчлөлт гарахад чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй, түүний нэг гол үр дагавар нь энэхүү өөрчлөлтөд улс төрчдийн хандлах хандлагад хүчтэй

нөлөөлсөн явдал юм. Улс төрчдийн конвергенцийн үйл явцад хандах эхний хандлага нь телехарилцааны зах зээлийг либералчлах, өрсөлдөөнийг дэмжихэд чиглэгдсэн хууль эрх зүйн баримт бичгүүдийг батлан гаргах үйлдлээр илэрч байв. Телехарилцааны зах зээлд хуучин монопольчлолыг хязгаарлах нь жижиг компаниудад зах зээлд нэвтрэх, үнэ тарифыг бууруулах, орчин үеийн мэдээлэл харилцааны бүхий л үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах явдал байлаа. Ялангуяа конвергенцийн үйл явц дэлхийн тэргүүлэгч хөгжингүй орнуудын, түүний дотор АНУ болон Европын Холбооны гишүүн орнуудын улс төрчдийн анхаарлын төвд байх болсон. 1996 онд АНУ-д батлагдсан Телехарилцааны тухай хууль, 1997 оны 12-р сард Европын Холбоо дэмжсэн Конвергенцийн тухай ногоон ном бол конвергенцийн үйл явцыг улс төрийн төвшинд дэмжихийг хүлээн зөвшөөрсөн хамгийн гол улс төрийн баримт бичгүүд юм.

Энэ хоёр баримт бичгийн гарах болсон гол шалтгаан нь электрон ОНМХ-үүдийг зохицуулж ирсэн хуучин зарчмууд нь долгионы тархалт хэт хязгаарлагдмал байсантай холбоотой байв. Конвергенци бол энэ асуудлыг бүрэн шийдсэнээрээ онцлог бөгөөд мэдээлэл харилцааны шинэ орчинд долгион хуваарилах шаардлагагүй болсон юм. Сувгууд ба мэдээллийн агуулгын нэгдлийн нөхцөлд мэдээллийн харилцаа өөрөө агуулга болон хувирдаг учраас радио, эсвэл телевизийн операторуудын сүлжээг хязгаарлахад үндэслэгдсэн хууль эрх зүйн уламжлалт дүрэм журамтай зөрчилдөж эхэлдэг. Тиймээс орчин үеийн

олон нийтийн харилцааны системд чөлөөтэй нэвтрэх нь улс орнуудын төрийн шинэ бодлогын төвшинд тавигдах болсон юм.

Конвергенцийн үр дүнд олон нийтийн мэдээллийн салбарт “оролцон тоглогчдын” тоо мэдэгдэхүйц өссөн. Энэ бол сүлжээний операторууд, нэвтрэх боломжийг хангагчид, мэдээллийн болон бусад бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэгчид бөгөөд тэдний идэвхтэй үйл ажиллагааг хэрэглэгчид тодорхойлдог онцлогтой.

Ө нөөдөр мэдээлэл харилцааны системд чөлөөтэй нэвтрэх явдал бол орчин үеийн улс төрийн бодлогын нэг чухал хэсэг болж байна. Монопольчлолыг хүчтэй болгоход нөлөөлж буй зах зээлийн конвергенци нь олон жижиг компани орчин үеийн мэдээллийн зах зээлд амжилттай ажиллах боломжийг хязгаарлах болсон. Нөгөө талаар технологийн дэвшлээс хоцрох явдал бол зарим орон, бүс нутгийн хувьд даяарчлагдсан мэдээлэл харилцааны дэд бүтцэд нэгдэн ороход ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Мөн хувь хүмүүсийн хувьд олон нийтийн мэдээллийн ертөнцөд чөлөөтэй нэвтрэхэд тэдний материаллаг байдал, эсвэл техник технологийн мэдлэг дутмаг зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Өнөөдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн конвергенцийн үйл явц практик дээр жирийн иргэдээс зардал мөнгө ба дадал чадвар, төр засаг болон улс төрийн холбоодоос нөөц боломж, улс төрийн эр зориг шаардах болсон. Мэдээлэл харилцааны хэрэгслүүдийн технологийн конвергенци ба эдийн засгийн зах зээлийн конвергенцийн үйл явц давхацдагийг бид сайн мэднэ.

Телехарилцааны операторууд кабелийн зах зээлд нэвтэрч, хэвлэх үйлдвэрүүд дүрс бичлэгийн компаниудтай нэгдэж, программ хангамжийн үйлдвэрлэгчид телесүлжээг сонирхох болсныг үүгээр тайлбарлаж болно. Гэхдээ иймэрхүү олон төвшний конвергенцийн үр дүнд мультимедиа концернууд хэвлэл, нэвтрүүлэг, телехарилцааны бизнес зэрэг ОНМХ-ийн уламжлалт үйлдвэрлэлээс ангид байж чадахгүй гэдэг нь тодорхой юм.

Бодит практикт технологиудын хоорондох (утас ба телевиз) зааг ялгаа тодорхой хугацаанд хадгалагддаг боловч орчин үед мэдээлэл харилцааны нэгдсэн шинэ бодлогыг боловсруулах шаардлагатай гэдэг нь бодит зүйл болсныг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна³. Европын Холбооны хүрэн дэх телехарилцааны зах зээлийг либералчлах орчин үеийн бодлого бол дэд бүтэц (мэдээллийг дамжуулах, холбох) ба мэдээллийн агуулгын, мөн энэхүү дэд бүтцийн тусламжтайгаар үзүүлж буй үйлчилгээний хоорондох зааг ялгаа, хуваарилалтыг маш тодорхой болгохыг чухалчилж байна. Тухайлбал, Конвергенцийн тухай ногоон ном (1997 он) бол тээвэрлэлт (уламжлалт ОНМХ-ийн хувьд түгээлт), үйлчилгээ ба мэдээллийн агуулгын хоорондох ялгааг тогтоож өгсөн байдаг. Энэхүү харилцан уялдаа холбоотой гурван хэсгийн дотроос бүтээгдэхүүний агуулгад гол анхаарлаа

хандуулсан нь ажиглагддаг. Гэхдээ технологийн конвергенцийн нөхцөлд янз бүрийн агуулга бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодит баталгааг мэдээлэл харилцааны зах зээлд нэгдэн нийлэх үйл явцад оролцогч бүх төрлийн хэрэглүүдэд таатай нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн тохиолдолд л өгч чадна. Өөрөөр хэлбэл, сүлжээний операторууд, нэвтрэх боломжийг бүрдүүлэгчид, мэдээллийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэр-

лэгчид, үйлчилгээ үзүүлэгчид зэрэг бүхий л оролцогчид олон нийтийн мэдээллийн шинэ системд чөлөөтэй, ижил төвшинд оролцох шаардлагатай болдог.

Уламжлалт ОНМХ-үүдийн үүргийг тодорхой хэмжээгээр өөрчлөх, дахин хуваарилахад хүргэсэн технологийн конвергенци бол хүлээн авагчдын үүр-

гийг ч давхар өөрчлөхөд нөлөөлж байна. Өгч буй ямар ч мэдээллийг хүлээн авч, тэвчээртэй хэрэглэдэг байсан идэвхгүй, нийтлэг шинжтэй хүлээн авагчид орчин үед мэдээллийн хэрэгцээ, харилцааны дадал нь нэлээд тодорхой болсон хэсэг, бүлэг болон хувиарч байна. Үүнээс гадна хоорондоо нэгдэж буй ОНМХ-үүдийн хүлээн авагчид өөр нэг онцгой чухал шинжийг агуулдаг болжээ. Энэ бол шинэ мэдээллийн хэрэгслүүдийн интерактив шинж нь ОНМХ-ийн уламжлалт хэрэглэгчдэд мэдээллийг чөлөөтэй сонгох хязгааргүй өргөн боломж олгож байна. Мөн үүний зэрэгцээ цахим мэ-

«

Хоорондоо нэгдэж буй ОНМХ-үүдийн хүлээн авагчид өөр нэг онцгой чухал шинжийг агуулдаг болжээ. Энэ бол шинэ мэдээллийн хэрэгслүүдийн интерактив шинж нь ОНМХ-ийн уламжлалт хэрэглэгчдэд мэдээллийг чөлөөтэй сонгох хязгааргүй өргөн боломж олгож байна.

»

дээллийн хэрэгслийг (on-line) хэрэглэгчид тодорхой төвшинд хянан найруулагч, бас мэдээллийн шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид болж хувирдаг. Өөрөөр хэлбэл, хүлээн авагч нэгэн зэрэг хэрэглэгч, үйлдвэрлэгч болж, урьд өмнө хоорондоо эрс ялгаатай байсан үүрэг, ажиллагаа нь нэгдэх болно. Ийм маягаар хэрэглэгч бүр конвергенцийн зорилго нь чиглэгдэж буй хүчин зүйл болж хувирдаг онцлогтой юм.

Хэрэглэгчдийг мэдээллийн шинэ хэрэгслүүдэд чөлөөтэй нэвтрэх боломжоор хангах нь конвергенцийн эриний тулгамдсан асуудал болж хувирч байгаа бөгөөд үүнийг зөвхөн телехарилцааны зах зээл дэх томоохон “тоглогчдын” хамтын ажиллагааны үр дүнд шийдвэрлэх боломжтой гэж үздэг байна. Хувийн бизнесийн болон хэрэглэгчдийн шууд, идэвхтэй оролцоо, тууштай дэмжлэгийн үр дүнд л төр засаг хүлээн авагчдын шинэ технологи, сүлжээ, Интернетэд нэвтрэх нийгэм-эдийн засгийн, мөн боловсролын баталгааг хангах болно.

Тогтмол хэвлэлийн кино, радио, телевизтэй өрсөлдөх явцад устаж үгүй болно гэсэн таамаглал Интернетийн эринд ч биелэгдэхгүй нь тодорхой болсон. Гэхдээ өнөөдрийн шалтгаан бол өмнөх үеийнхээс улам нарийн төвөгтэй, ээдрээтэй юм. Учир нь ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явц урьд өмнө тодорхой бус байсан олон шинэ зүйлийг бий болгохын зэрэгцээ багагүй сөрөг үр дагавар дагуулж ирснийг амархан ажиглаж болно. Аливаа улс орны улс төрийн эр зориггүйгээр, хувийн бизнесийн шинэчлэл, эрчимтэй үйл ажиллагаагүйгээр, хүлээн авагчдын идэвх

зүтгэлгүйгээр конвергенци бол ирээдүйг судлаачдын хэлж байсанчлан зөвхөн боломж төдий зүйл болон үлдэх нь тодорхой юм.

Ишлэл

- ¹ 1999. Информационное общество. Вып. 5. М., с. 15.
- ² *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 18 дахь тал.
- ³ *Черных А.* 2004. Мир современных Медиа. М., с.154.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Болд-Эрдэнэ Б.* 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
2. *Зулькафиль М.* 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.
3. *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
4. 1999. Информационное общество. Вып. 5. М.
5. 1996. Словарь иностранных слов. М.
6. *Черных А.* 2004. Мир современных Медиа. М.
7. *Цвик В. Л.* 2009. О конвергенции в журналистской науке // Вестник электронных и печатных СМИ. Вып. 10.

Summary

The author wrote about the function of convergence, one of the major factors in defining the modern journalism improvement in the article. The author pointed out the convergence concepts and ideologies of international scientists, identified theoretical and practical significances of economic, political, and other factors affecting the journalism development and reflected advantages and disadvantages on the basis of examples and facts of the modern mass press and media outlets.